

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Д.ОЮУНСУВД ТАНАА

2020.02.27 № 06/617  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


1. Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг баталгаажуулж ирүүлээгүй 9 хоног хоцроосон.
2. Хоол, хүнсний материалыг сонгон шалгаруулалт зарлалгүй 140,051.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 13,772.3 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулсан зэрэг нь санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Оюунсүвд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын дотоод хяналт болон, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-ийн захирал Д.Баатарсайхан, аудиторын туслах Р.Гомбо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн эрхэм зорилго нь “Чанартай боловсрол, зөв хөгжил төлөвшил бидний ирээдүй” уриан дор багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, эцэг эх асран халамжлагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргахад оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан түвшний боловсрол эзэмшүүлэх;
- Хүүхдийн сурлага, хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Сургуулийн дотуур байрны гадна, дотно орчны аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн 2019 онд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад хангалтгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн

санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож суурь үзүүлэлтийн дүнг 2,164,648.5 мянган төгрөгөөс тооцон 21,646.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас материаллаг байдлын түвшинг 31,289.6 мянган төгрөгөөр тооцсон нь нягтлан бодогчийн ажлын ур чадвар, өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг эрсдэлтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,298.4 мянган төгрөг буюу 3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	66,971.1	82,232.0	15,260.9
Үндсэн хөрөнгө	5,564,361.7	5,577,109.1	12,747.4
Хуримтлагдсан элэгдэл	(659,341.3)	(831,648.1)	(172,306.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,971,991.5</b>	<b>4,827,693.0</b>	<b>144,298.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,971,991.5	4,827,693.0	144,298.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,971,991.5</b>	<b>4,827,693.0</b>	<b>144,298.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь барааны үнийн хэлбэлзэл болон хүүхдийн тоо, хоолны нормоо буруу тооцоолсноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,907.4 мянган төгрөг, хандав тусламжаар 5,840.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн, 172,306.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,827,693.1 мянган төгрөг болж 144,298.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,964,506.6 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.



Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээтэй холбоотой батлагдсан санхүүжилт болон гүйцэтгэл байхгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,551,388.1 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа төлөвлөлттэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 13,255.4 мянган төгрөгийн орлогыг хуваарилсан байна.

Үүнээс ном, хэвлэлд 7,885.4 мянга, тавилга эд хогшилд 1,560.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх хөрөнгөнд 1,610.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсөнд 1,820.0 мянга нийт 12,875.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 380.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж, нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илрүүлсэн нийт 153,823.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй 153,823.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулалт зарлалгүй 140,051.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 13,772.3 мянган төгрөгийг түлш, шатахууны зардалд зарцуулсан нь НББТухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3. Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй тул 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр тайлан ирүүлэх талаар албан бичиг явуулсан боловч санхүүгийн тайлан гаргалгүй эхэлж анхан шатны баримт ирүүлсэн, сургуулийн захирлын гарын үсэг, тамга тэмдэггүй, санхүү үр дүнгийн тайланд санхүүжилтийн орлого хасах дүнтэй, төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн дутуу ирүүлсэн тул тухай бүр буцаагдаж 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр санхүүгийн тайланг баталгаажуулан ирүүлж цаглабарт хугацаанаас 9 хоног хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах,



тогтоосон хугацаанд тайлагнах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

- Шүүхийн шатанд шийдвэрлэгдээгүй байгаа ажлаас халагдсан ажилчдын маргааны эцсийн шийдвэрт хяналт тавьж, хохирлыг буруутай албан тушаалтнаар барагдуулахад анхаарах,
- Анхан шатны баримт бүрдүүлэлтэд Ибаримт байхгүй байгаа тул цаашид анхан шатны баримтад авч байх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль 2019 онд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 100 мэдээллийг хугацаанд нь, 36 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг бүтэн жилээр байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,327.5 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 1,606.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 1,606.0 мянган төгрөгийн албан шаардлага бүрэн биелэгдэж 1 албан шаардлагын хэрэгжилт 50 хувьтай байна.

Нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 153,823.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 31,289.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс хэтэрч байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Байгууллагын дансанд бүртгэлтэй суудлын автомашины техник ашиглалтын паспорт байхгүй, жолоочийн замын хуудсанд спедометрийн заалт тэмдэглээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны А/496 дугаар тушаалыг дагаж мөрдөөгүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бус ашиглах, зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллана.

#### 2. НБББББ-тэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2019 онд орсон шинэчилсэн хууль, журам заавруудыг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь / Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана/ заалтыг биелүүлээгүй.

2.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлаагүйгээс нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтлөх

2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн баримталж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллана.

### 3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль 2019 онд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 100 мэдээллийг хугацаанд нь, 36 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг бүтэн жилээр байршуулаагүй байна.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн зориулалт, ашиглалт, зарцуулалт ил тод бус байх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66,971,083.45</b>	<b>82,232,015.55</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	66,971,083.45	82,232,015.55
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,441,931.15	15,517,910.65
35110	Тусгай зориулалттай материал	274,498.00	00.00
35130	Эм боох материал	14,167,433.15	15,517,910.65
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,529,152.30	66,714,104.90
35410	Бичиг хэргийн материал	1,256,700.00	2,138,830.00
35420	Аж ахуйн материал	8,457,100.00	4,547,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	3,652,720.00	5,597,220.00
35450	Барилгын засварын материал	4,661,350.00	5,094,850.00
35460	Хүнсний материал	3,584,269.60	1,742,989.00
35470	Бусад хангамжийн материал	30,917,012.70	47,592,715.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,905,020,366.80</b>	<b>4,745,461,041.06</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,905,020,366.80	4,745,461,041.06
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,359,556,046.80	4,199,996,721.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,082,676,048.00	4,082,676,048.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,939,600.00	-173,021,420.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,974,891.00	126,974,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,421,959.05	-44,684,422.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	515,427,768.22	523,697,558.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-340,594,880.86	-390,640,467.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	173,776,182.47	177,384,932.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,744,874.83	-135,274,785.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	98,746,354.40	98,746,354.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-85,100,000.00	-86,486,985.44
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	19,756,117.45	20,625,017.45
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	545,464,320.00	545,464,320.00
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.00	-1,540,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	545,464,320.00	545,464,320.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,971,991,450.25</b>	<b>4,827,693,056.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,971,991,450.25</b>	<b>4,827,693,056.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,971,991,450.25	4,827,693,056.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,767,655,847.77	2,767,655,847.77
51101	Өмч: - төрийн	2,767,655,847.77	2,767,655,847.77
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-833,228,973.86	-977,527,367.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-833,228,973.86	-833,228,973.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-144,298,393.64
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,037,564,576.34	3,037,564,576.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,971,991,450.25</b>	<b>4,827,693,056.61</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,157,843,013.00</b>	<b>2,984,661,834.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39,313,113.00</b>	<b>6,899,834.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	39,313,113.00	1,059,834.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,313,113.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,451.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,285,662.00	00.00
120009	Бусад орлого	00.00	1,059,834.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	00.00	5,840,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	5,840,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,118,529,900.00</b>	<b>2,977,762,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,079,862,300.00	2,964,506,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,079,862,300.00	2,964,506,600.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	38,667,600.00	13,255,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,667,600.00	13,255,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,163,633,985.70</b>	<b>3,128,960,227.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,163,633,985.70</b>	<b>3,128,960,227.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,115,420,946.96	2,619,852,763.79
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,451,299,625.71	1,934,089,436.35
210101	Үндсэн цалин	1,451,299,625.71	1,934,089,436.35
210102	Нэмэгдэл	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	167,188,134.68	143,743,626.83
210201	Тэтгэврийн даатгал	115,805,533.47	102,551,868.43
210202	Тэтгэмжийн даатгал	13,526,040.67	11,675,628.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,196,764.65	7,311,944.06
210204	Ажилгүйдлийн даатгал	2,417,128.31	3,924,325.30
210205	Эрүүл мэндийн даатгал	23,242,667.58	18,279,860.14
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	104,635,361.87	110,776,009.47
210301	Гэрэл, цахилгаан	32,768,410.00	28,979,805.00
210302	Түлш, халаалт	38,815,354.00	42,488,568.21
210303	Цэвэр, бохир ус	33,051,597.87	39,307,636.26
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	74,575,653.63	51,840,015.00
210401	Бичиг хэрэг	7,687,250.00	5,321,310.00
210402	Тээвэр, шатахуун	10,984,700.00	11,827,800.00

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,246,300.00	3,387,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
